



УЛААНБААТАР хотын Ардын Депутатуудын хурлын Гүйцэтгэх Захиргааны ТОГТООЛ

Улаанбаатар хот

1978 оны 3 дугаар сарын 22 ны өдөр

Дугаар 50

1990 оны 140 д тогтоолоор хүчингүй

ЗӨВЛӨЛ БАЙГУУЛЖ, ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргаанаас ТОГТООХ НЬ:

I. Улаанбаатар хотын АДХ-ийн Гүйцэтгэх Захиргааны Ардын Боловсролын хэлтсийн зөвлөлийг доорхи бүрэлдэхүүнтэйгээр байгуулж дүрмийг баталсугай.

/ дүрмийг хавсаргав. /

- Дарга: Бат-олзийт /Ардын боловсролын хэлтсийн дарга,
- Нарийн бичгийн дарга: Цэнд-авуун /хотын СЗАН-ийн эрхлэгч/
- Гшшүүдэд: Нүдэмхүү /хотын ХЗЭ Хорооны нарийн бичгийн дарга /
- Баяраа /Хотын ҮЭ-ийн Зөвлөлийн нарийн бичгийн дарга/
- Бөөрөн /хотын Намын Хорооны Үзэл суртлын хэлтэст зохион байгуулагч/
- Нямдорж /Хотын БТСЭ Зөвлөлийн орлогч дарга /
- Цэдэнсамба /СБ районы АБ хэлтсийн дарга/
- Бор / МУИС-ийн багш/
- Лувсаншарав /Цагдаа сэргийлэх газрын хүүхдийн хэлтсийн дарга/



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

1-Р ОРЛОГЧ ДАРГА *[Signature]* Л.ДУГАРЛАВ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА *[Signature]* Д.ДАМДИНСҮРЭН



187

Хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны
1973 оны 50-р тогтоолоор батлав.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ АРДЫН БОЛОВСРОЛЫН ХЭЛТСИЙН ЗӨВЛӨЛИЙН

ДҮРЭМ .

Зөвлөл нь хотын Ардын боловсролын хэлтсийн дэргэдэх зөвлөл
эрхтэй байгууллага бөгөөд АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны тогтоо-
лоор байгуулагдана.

ЗОРИЛГО НЬ:

а/ ЗХУ-ын Ардын боловсролын байгууллагын туршлаганд тул-
гуурлан сургалт хүмүүжил, сургууль сургалтын материаллаг басыг
бэхжүүлэх түүнд тавих хяналт-налгалтын ажилд олон нийтийн бай-
гууллагын оролцоог улам сайжруулж нэгдмэл удирдлага зохион
байгуулалтаар хангах;

б/ хичээл хүмүүжлийн ажлын үр дүн, төлөвлөлт, удирдла-
гын арга барилыг улам боловсронгуй болгохтой холбогдсон аргач-
лал, зөвлөмж боловсруулж өгөх.

БҮРЭЛДЭХҮҮН:

а/ зөвлөл нь хотын ХЗЭ-ийн хороо, Ардын боловсролын
хэлтэс, Үйлдвэрчний эвлэл, Биеийн тамир спортын эвлэлийн зөвлөл
зэрэг байгууллагуудын удирдах ажилтнуудаас бүрдэнэ.

б/ зөвлөлийг дарга, нарийн бичгийн дарга, гишүүд зэрэг
5-9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

АЖИЛЛАХ ЖУРАМ:

а/ ажлаа жил улирлаар төлөвлөж хотын Ардын боловсролын
хэлтэст тайлагнаж байна.

б/ зөвлөлийн хурлыг сард 1-2 удаа хийж протокол гаргана.

в/ хотын ардын боловсролын байгууллагын хэмжээгээр
дагаж мөрдвөл зохих зарим зүйлийг протоколын дагуу олонхийн
саналыг үндэслэн холбогдох байгууллагууд 7 хоногийн дотор эрхийн
акт болох удирдамж гаргана.

г/ хуралд оруулах асуудлыг зөвлөлийн нарийн бичгийн дарга боловсруулж тухай бүрднэ протокол хөтлөж гарын үсэг зурна.

ГҮЙЦЭГТЭХ АЖИЛ:

1. Сургууль ардын боловсролын байгууллагын үүрэг хариуцлага, сурлага хүмүүжлийн ажлын чанарыг сайжруулахтай холбогдсон тухаад тогтоол, албан даалгавар зэрэг удирдамжуудыг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар захирал, эрхлэгч, хот, районы ардын боловсролын хэлтсийн удирдах ажилтны илтгэл сонголыг авч хэлэлцэн зөвлөмж гаргаж өгөх.

2. Сургууль цэцэрлэгийн хэмжээгээр жил улиралд тавих үндсэн зорилтыг хэлэлцэж түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зөвлөмж боловсруулах.

3. ШБС, сурган хүмүүжүүлэх тэргүүн туршлагыг нэгтгэн дүгнэж нийтийн хүртээл болгох, нэвтрүүлэх арга зүйн талаар аргачлал боловсруулж гаргах.

4. Сургууль цэцэрлэгийн дунд социалист уралдаан өрнүүлэн явцыг нэгтгэн дүгнэх хэрхэн нэвтрүүлж байгааг авч хэлэлцэх, хотын хэмжээгээр зарлагдсан болзолт уралдааны дүнг хэлэлцэн тогтоох.

5. Хичээлээс гадуур сурагчдын дунд зохиогдох хүмүүжлийн ажлын агуулга хэлбэр үр дүнг сайжруулахтай холбогдсон заавар, зөвлөмж аргачлалыг хэлэлцэх тэргүүний ажиллагаатай сургууль, цэцэрлэг, анги, бүлэг, үүр, зөвлөлийн хамтлагыг тогтоож өгөх.

6. Хот, районы ардын боловсролын хэлтэс зарим холбогдох байгууллагын илтгэл сонгоол, мэдээлэлийг сэдэвчлэн авч хэлэлцэх.

7. Эцэг эхийн дунд явагдах сурган хүмүүжүүлэх суртал нэвтрүүлэгийн ажлыг чанаржуулахын тулд эцэг эхэд заах хичээлийн программ сэдвийг боловсруулж хэлэлцэх.

8. Сурагчдын хүмүүжил, ариун цэвэр эрүү ахуй, соёлжилтын ажил, түүнд улс, олон нийт ам ахуй, соёлын байгууллагаас үзүүлэх тусалцааны талаар зөвлөмж гаргах.

9. Нийт сургуулиудын дунд явагдах нийгмийн туст хөдөлмөр, урлаг, спортын болзолт уралдаан тэмцээний заавар, дүнг хэлэлцэх.

10. Ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгийн шалган зааварлах графикийг батлах, шалгалтын дүнг райончлон хэлэлцэх.

11. Зарим сургуулийн захирал, эрхлэгч, багш нарын илтгэл сонголыг программын биелэлт, сургалтын шинэ системийг хэрэгжүүлж буй арга барил, сургалтанд тавих дотоодын кяналт шалгалт, багш нарын хөдөлмөр зохион байгуулалт мэдлэг мэргэжлийг хэрхэн дээшлүүлж байгаа тухай мөн тэдний эрүүл мэнд, ахуй хангамж цаашид авах арга хэмжээ зэрэг асуудлуудыг авч хэлэлцэх.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН БОЛОВСРОЛЫН

Х Э Л Т Э С .